

**ҮАГ**

Үндэсний аудитын газрын 2004 оны  
бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний  
төлөвлөгөөг үндэслэн хийсэн гүйцэтгэлийн  
аудитын тайлан

---

2004 оны 11 дүгээр сар

**САНХҮҮГИЙН  
УДИРДЛАГЫГ  
САЙЖРУУЛАХ  
ШААРДЛАГАТАЙ  
БАЙНА**

Байгаль орчны сайдын эрхлэх  
асуудлын хүрээний  
байгууллагуудын үйл  
ажиллагаа

---

## Агуулга

---

|                                     |  |    |
|-------------------------------------|--|----|
| <b>Ерөнхий зүйл</b>                 | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй   | 2  |
|                                     | Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд  |    |
|                                     | Аудитын стандартын талаархи мэдэгдэл   | 2  |
|                                     | Аудит хийх явцад гарсан хүндрэл бэрхшээл   |    |
|                                     |  | 2  |
|                                     |  | 3  |
| <b>Аудитын дүн</b>                  | Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний хэтийн болон жилийн зорилт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт | 4  |
|                                     | Санхүүгийн үр дүнг тайлагнасан байдал  | 5  |
|                                     | Төсвийн зарцуулалтын арвиг хямгач, үр ашигтай байдал   | 6  |
|                                     | Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт  | 17 |
| <b>Дүгнэлт</b>                      |  | 23 |
| <b>Холбогдох байгууллагын санал</b> | Байгаль орчны яамны санал  | 24 |
| <b>Зөвлөмж</b>                      |  | 25 |
| <b>Хавсралт</b>                     | Хавсралт № 1   | 27 |
|                                     | Хавсралт № 2   | 28 |
|                                     | Хавсралт №3  | 29 |
|                                     | Хавсралт № 4   | 30 |
|                                     | Хавсралт № 5   | 31 |
|                                     | Хавсралт № 6   | 32 |
|                                     | Хавсралт №7  | 33 |

---

## Ерөнхий зүйл

---

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль, ой, усны нөөцийн газар, Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2003 он, 2004 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд хэсэгчилсэн байдлаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Дээрх байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дараахь асуудлыг хамруулан шалгаж дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл түүнийг арилгах санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний хэтийн болон жилийн зорилт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн үр дүнг тайлагнасан байдал
- Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу арвигч хямгач, үр ашигтай зарцуулсан эсэх
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандартын дагуу холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, тайлбар, нотолгоо авах, орлого, зарлагыг анхан шатны баримтаар түүвэрлэн шалгах, тулган баталгаажуулах, төсөвт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан хийлээ.

---

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дээрх зорилтыг ханган биелүүлэхийн тулд сонгон авсан шалгуур үзүүлэлтүүдийг аудитын зорилттой уялдуулан хавсралт №1-д үзүүлэв

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, судалгаа, холбогдох бусад мэдээллийг ажлын

---

## Ерөнхий зүйл

---

баримт материалд хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн Төрийн төв байгууллагын багийн аудитор, шинжээч нар 2004 оны 9 дүгээр сарын 8-наас 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудит хийх  
явцад гарсан  
хүндрэл  
бэрхшээл

Аудитад хамрагдсан байгууллагууд аудит хийхэд шаардагдах мэдээ, тайлан, холбогдох баримт материалыг тухай бүр гаргаж өгөхгүй 3-4 удаа ам болон бичгээр шаардуулж байсан нь шалгалтын явцад хүндрэл учруулж байлаа.

---

## Аудитын дүн

---

Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний хэтийн болон жилийн зорилт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дахь зүйлд Байгаль орчны сайд дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, улсын хяналт шалгалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэн явуулахаар заасан байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- Газрын хэвлийн баялаг, ой, ус, ан амьтан, ургамлын нөөцийг хамгаалах бодлого, мэдээллийн сан;
- Байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур, байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах бодлого.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөр, Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүд болон эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд байгаль орчны талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2003 онд тавьсан зорилт, түүний биелэлтийг хавсралт №2-д үзүүлэв.

Дээрх зорилтыг хангахын тулд Байгаль орчны яам тайлангийн хугацаанд 15 ангийн 44 нэрийн бүтээгдэхүүн төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлжээ.

Байгаль орчны сайдтай Ерөнхий менежерийн байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 96,5 хувьтай байна.

Байгаль орчны сайд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий менежерүүдийн хооронд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 88,4 хувьтай байна.

Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан дараахь ажлын хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:

- Монголын экотуризмын 2 дугаар зөвлөгөөнийг Японы Жайка байгууллага болон Дэд бүтцийн яамтай хамтран зохион байгуулах
- Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг батлуулах
- Байгаль орчныг хамгаалах, эдэлбэр газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулах
- Экологийн аялал жуулчлалыг дэмжих талаар асуудал боловсруулж шийдвэрлүүлэх
- Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотод хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах үйлдвэр байгуулах.

---

## Аудитын дүн

---

Санхүүгийн үр дүнг тайлагнасан байдал

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.1 дэх заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн жилийн эцэст өөрийн үйл ажиллагааны үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг төрийн аудитын төв байгууллагын аудитын дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулах үүрэгтэй.

Байгаль орчны сайд 2003 оны үйл ажиллагааны үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн 39.2-т заасны дагуу Үндэсний аудитын газарт нэгтгэж ирүүлээгүй тул 2003 оны санхүүгийн тайланд аудит хийлгээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 60.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан хуваарийн дагуу Байгаль орчны сайдын төсвийн багцад санхүүгийн тайлангийн аудит хийхээр томилогдсон аудиторуд холбогдох баримт материалыг гаргаж өгөхийг удаа дараа шаардаж байжээ.

Төсвийн байгууллагууд Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 91 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Улс, орон нутгийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын дагуу өөрийн үйл ажиллагааныхаа онцлогт тохируулан тухайн байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, энэ баримт бичгийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 40, 41 дэх зүйл, Сангийн сайдын 1997 оны 441 дүгээр тушаалаар баталсан “Төсөвт зардлыг төсвийн эдийн засгийн ангилалд тусгах аргачлал” зэрэг хууль эрхийн актыг баримтлан өөрийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг тайлагнах ёстой.

Аудитад хамрагдсан байгууллагууд санхүүгийн үр дүнг хэрхэн тайлагнасан байдлыг холбогдох баримт материалд тулгуурлан шалгахад дээрх байгууллагууд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж баталгаажуулаагүйн гадна тус яамны ажлын алба, Байгаль, ой, усны нөөцийн газар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг батлагдсан маягт, зааврын дагуу бүрэн хөтлөөгүй, өр авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, ажил гүйлгээг данс бүртгэлд буруу бүртгэж мэдээ, тайланг будлиантуулсан зөрчил илэрлээ.

Байгаль орчны яамны аппаратын 2003 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээс харахад тайлангийн хугацаанд 13220,1 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсны дотор Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 1543,2 мянга, Мобиком корпорацид 4502,8 мянга, Монголын цахилгаан холбоо компанид 1061,0 мянга, Төр засгийн үйлчилгээний авто баазад 1543,2 мянган төгрөгийн өртэй гэж тайлагнажээ.

Энэ өр төлбөрийн үүссэн шалтгааныг тодруулбал 2001 оны 7 дугаар сарын 1-нээс Засгийн газрын 3 дугаар байрын захиргаа Байгаль орчны

---

## Аудитын дүн

---

яамны санхүүгийн үйл ажиллагааг салган өгөхдөө дээрх байгууллагуудад өр төлбөргүй хүлээлгэн өгсөн байхад тус яам 2001 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа оны эхэнд Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 3524,9 мянга, Төр засгийн үйлчилгээний автобаазад 1234,9 мянга, Монголын цахилгаан холбоо ХК-д 5861,5 мянган төгрөгийн өртэй байсан гэж тайлан тэнцлийг бодит байдлаас өөрөөр гаргажээ.

Байгаль орчны яам, Байгаль, ой, усны нөөцийн газрын санхүү, бүртгэлийн ажилтнууд бараа материал, үндсэн хөрөнгө худалдаж аваад бүртгэл тайланд тусгалгүй шууд зардалд бичих, зардлын шинж чанартай ажил гүйлгээг бараа, материал, үнэ бүхий зүйлийн тайланд бүртгэх зэргээр данс бүртгэлийг будлиантуулж, төсвийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.

Байгаль орчны яамны Санхүү, төсвийн хэлтсийн мэргэжилтэн Ш.Ганзориг бараа материалын нэр төрлийн тайланд гар утасны засварын хөлс 26,5 мянга, Монголын сагсан бөмбөгийн холбоонд бэлнээр шагналд зарцуулсан 300,0 мянга, гар утасны гадаадад ярих эрхийн баталгаа 200,0 мянга, гадаадын зочин төлөөлөгчдийн хоолны зардал 225,0 мянган төгрөгийг тус тус хөрөнгө авсан мэтээр тусгасан байна.

Байгаль, ой, усны нөөцийн газарт 11,1 сая төгрөгийн үнэтэй PAJERO маркийн жип машины үнийг Байгаль хамгаалах сангаас шилжүүлэн өгч худалдан авсан боловч өнөөг хүртэл данс бүртгэлд тусгаагүй байсан тул аудитын явцад уг машиныг нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд тусгахыг зөвлөв.

Энэ нь Байгаль орчны яамны санхүү, бүртгэлийн ажилтнуудын нягтлан бодох бүртгэлийн болон хууль тогтоомжийн мэдлэг, мэргэшил зохих шаардлагын хэмжээнд хүрээгүй, тус яамны Санхүү, төсвийн хэлтсийн дарга болон холбогдох албан тушаалтны хариуцлагагүй ажиллагаанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тайлагнахгүй байгаа нь яамны удирдлагад буруу ташаа мэдээ, мэдээлэл хүргээд зогсохгүй улсын төсвийн нэгдсэн тайлан мэдээ бодит байдлаас зөрүүтэй гарахад нөлөөлж байна.

Төсвийн зарцуулалтын арвич хямгач, үр ашигтай байдал

2003 онд байгаль орчны салбарт зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө улсын төсвийн нийт зарлагын 0,73 хувийг эзэлж байна.

2003 оны төсвийн тухай хуулиар Байгаль орчны сайдын төсвийн багцыг 4287,3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 4294,8 сая төгрөг зарцуулан батлагдсан төсвийг 7,5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Байгаль орчны сайдын төсвийн багцын 2003 оны гүйцэтгэл, түүнд хийсэн шинжилгээний дүнг хавсралт № 3-д үзүүлэв.

---

## Аудитын дүн

---

Дээрх материалаас харахад Байгаль орчны сайдын 2003 оны төсвийн багцын 58,3 хувь буюу 2499,2 сая төгрөгийг Байгаль орчны яам, 8 агентлаг, байгууллагын үйл ажиллагааны зардалд, 34,8 хувь буюу 1490,4 сая төгрөгийг байгаль орчны төвлөрсөн арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засвар болон ойжуулалтын ажилд, 6,9 хувь буюу 297,7 сая төгрөгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

2003 онд батлагдсан төсвийг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 2,3 хувь буюу 34,6 сая, байгаль орчныг хамгаалах албад 15,4 хувь буюу 74,4 сая, Усны үндэсний хороо 20,8 хувь буюу 1,4 сая төгрөгөөр тус тус хэмнэж, Ус, цаг уурын хүрээлэн 3,1 хувь 2,7 сая, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 8,8 хувь буюу 14,5 сая, Байгаль орчны мэдээлэл, тооцооллын төв 0,4 хувь буюу 0,3 сая, Байгаль, ой, усны нөөцийн газар 49,2 хувь буюу 14,0 сая, Байгаль орчны яамны ажлын алба 11,05 хувь буюу 16,0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас бусад 12 хамгаалалтын захиргаад 2003 онд батлагдсан төсвийг 0,16-220,73 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

Байгаль орчны яамны ажлын албаны төсөвт зардлын гүйцэтгэлийг зардлын зүйл тус бүрээр авч үзвэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7.8 сая, шуудан холбооны зардлыг 5.8 сая, гадаад албан томилолтын зардлыг 5.2 сая, дотоод албан томилолтын зардлыг 1.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсны гадна аж ахуйн материал худалдан авах, сургалтын зардалд төсөв батлагдаагүй байхад 4,3 сая төгрөг дур мэдэн зарцуулжээ.

Цалин хөлс, нийгмийн даатгалын зардал хэтэрсэн шалтгаан нь бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

Байгаль, ой, усны нөөцийн газар батлагдсан төсвийг 49,2 хувь буюу 14,0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь гадаад албан томилолтын зардлыг 1778,2 мянга, Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1978,2 мянга, тусгай үйлчилгээний зардлыг 1778,2 мянга, бусад зардлыг 1007,6 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэнтэй холбоотой байна.

2003 оны ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд 625,4 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 628,6 сая төгрөг зарцуулсан нь Байгаль орчны сайдын төсвийн багцын нийт зардлын гүйцэтгэлийн 14,6 хувийг эзэлж байна.

2003 онд улсын хэмжээнд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлыг 5195 га талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5233 га талбайд хийж гүйцэтгэжээ.

2001 – 2003 онд 4034,7 га таримал ойг улсын ойн санд шилжүүлсэн нь ойн санд шилжүүлсэн нийт талбайн 45,6 хувь болж байна.



## Аудитын дүн


1990 оноос үр бэлтгэх, тарьц, суулгац ургуулах зэрэг ажил үндсэндээ зогсож ойн чиглэлийн мэргэжилтнүүд ажилгүй болсон байна.

Харин 1997 оноос ойн аж ахуйнууд хувьчлагдаж, зах зээлийн өрсөлдөөнөөр ойн мэргэжлийн хүмүүс аж ахуйн нэгж байгуулан, тарьц, суулгац ургуулах болсон нь тодорхой үр дүнд хүрчээ.

Байгаль, ой, усны нөөцын газраар дамжуулан 2003 онд хийсэн ойжуулалт, ойн арга хэмжээний зардлын бүтцийг доорх хүснэгтээр үзүүлэв.

| № | Арга хэмжээний нэр                               | Хэмжих нэгж | Ажлын хэмжээ | Зардал сая.төг |
|---|--|-------------|--------------|----------------|
| 1 | Ойг нөхөн сэргээх арга хэмжээнд                  | га          | 5233         | 428.2          |
| 2 | Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх арга хэмжээнд | га          | 5828         | 45.1           |
| 3 | Ой зохион байгуулалтын ажилд                     | Мянган га   | 1188         | 50.0           |
| 4 | Ойн үрийн лаборатори, үрийн сан                  |             |              | 3.1            |
| 5 | Модлог ургамлын цэцэрлэг                         |             |              | 5.6            |
|   | Дүн  |             |              | 532.0          |

Ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг 1996 оныг 2003 онтой харьцуулан үзэхэд 2,8 дахин өссөн байна.



Ойжуулах ажлын технологийн мөрдөлтөд тавих хяналтыг сайжруулан ойжуулах шаардлагатай талбайг зөв сонгох, сайн чанарын үрээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр улсын хэмжээгээр ойжуулах ажлын чанар, амьдралтын хувь хэмжээнд тодорхой ахиц гарсныг доорх хүснэгтэд харуулав.

|          |    |
|----------|----|
| Үзүүлэлт | Он |
|----------|----|

## Аудитын дүн

|  | 1997 | 2000 | 2001 | 2002 | 2003 |
|--|------|------|------|------|------|
| Ойжуулалтын ажлын амьдралтын дундаж хувь | 55   | 60   | 62   | 65   | 70   |



Ойг нөхөн сэргээх, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилтай холбоотой судалгаа, шинжилгээ, түүнд зарцуулагдаж байгаа хөрөнгийн хэмжээ хангалтгүй, цаг хугацаа алдаж хийгдсэнээс ажлын горим алдагдаж, ойжуулалтын ажлын эцсийн үр дүнд муугаар нөлөөлж байна.

**Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрхэн арвигч хямгач, үр ашигтай зарцуулсан эсэхэд дүгнэлт өгөх зорилгоор Байгаль орчны яамны аппарат, Байгаль, ой, усны нөөцийн газар холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаа, санхүү, төсвийн гүйцэтгэлийг шалгалаа.**

Аж ахуйн нэгж, байгууллага хөрөнгийн хөдлөл өөрчлөлт бүрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дэх зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл хөтөлж, мөн хуулийн 10 дэх зүйлд

---

## Аудитын дүн

---

заасны дагуу тайлагнах ёстой.

**Аудитад хамрагдсан байгууллагууд төсвийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг хууль тогтоомжийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, хуурамчаар үйлдсэн, ажил гүйлгээг данс бүртгэлд буруу тусгасан, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.**

Зөрчлийн жагсаалтыг хавсралт № 4-д үзүүлэв.

Байгаль орчны сайд Завхан аймгийн Засаг дарга Д.Батмөнхийн хүсэлтийг үндэслэн 2004 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 99 дүгээр тушаал гаргаж, Отгонтэнгэр уулыг тайх төрийн ёслолын бэлтгэл ажлын хүрээнд Отгонтэнгэрийн тусгай хамгаалалттай газрын Богдын өврийн гол дээрх модон гүүрний зардалд 10.0 сая төгрөгийг Байгаль орчны 2004 оны төвлөрсөн арга хэмжээнээс санхүүжүүлжээ.

Энэхүү гүүрийн ажлын гүйцэтгэл, ашиглалт, гүүр барих ажилд зориулж өгсөн дээрх хөрөнгийн зарцуулалтын байдлыг шалгахад үзэхэд уг гүүрийг орон нутгийн цэргийн дүйцүүлэх албаны цэргүүдийн хүч оролцоотойгоор хандив, зээлийн хөрөнгөөр гүйцэтгэсэн бөгөөд гүүрний зардалд өгсөн хөрөнгийг гүүр барих ажилд зарцуулалгүй аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан нь тогтоогдлоо.

Байгаль орчны яаманд гаргаж өгсөн Завхан аймгийн Засаг дарга Д.Батмөнхийн баталсан “Отгонтэнгэрийн дархан цаазат газрын Богдын өврийн голын модон гүүрийн ажлын гүйцэтгэл”-ээс харахад “АЗЗА-ЗАВХАН” ХХК гүүр барих ажлын гүйцэтгэгчээр ажилласан мэтээр хуурамч баримт бүрдүүлж, цалинд 10,3 сая, материалын зардалд 8,9 сая, тээврийн зардал 3,9 сая төгрөг тус тус зарцуулснаар гүйцэтгэл гаргасан байна.

Дээрх ажлын материалын зардалд 232,3 м<sup>3</sup> гуалинг 6,5 сая, 27,6 м<sup>3</sup> 5 см-ийн банзыг 1,2 сая, 198 кг хадаасыг 0,3 сая төгрөгөөр худалдан авч зарцуулсан мэтээр тайлагнажээ.

Гүүрийн ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь очиж танилцахад дээр дурдсан хэмжээний материал уг гүүрэнд зарцуулагдах үндэсгүй гэдэг нь тогтоогдлоо. Уг гүүрэнд 4 метрийн урттай 27 ширхэг гуалин (ойролцоогоор 3,6 м<sup>3</sup>), 4 метрийн урттай 4-ийн банз 20 ширхэг банз (ойролцоогоор 0,48 м<sup>3</sup>) зэрэг материал зарцуулсан байна.

Гүүрийн фото зургийг Зураг №1, 2-д үзүүлэв



Зураг №1



Зураг №2

Байгаль орчны төвлөрсөн арга хэмжээний зардлаас Японы Ерөнхий сайдыг хүлээн авахад зарцуулсан 15.6 сая төгрөгийн зарцуулалтыг шалгахад анхан шатны баримт, материалын бүрдэлт бүрэн бус, 10,0 сая төгрөгийг бэлнээр авч кассын гадуур зарцуулсны дээр нэг бүр нь 124987 төгрөг 50 мөнгөний үнэ бүхий 4 ширхэг мөнгөн зүүлтийг худалдан авч Японы зочдод өгснөөр баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь илэрсэн тул 499,9 мянган төгрөгийг төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо.

Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын албан ажлын хэрэгцээнд SCH-X580 маркийн гар утсыг 500,0 мянган төгрөгөөр, MOTOROLA V730 маркийн гар утсийг 400,0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч хангамжийн материалын дансанд үлдэгдлээр бүртгэсэн гэх боловч тооллогын бүртгэл байхгүй байлаа.

Байгаль орчны сайдын зөвлөлийн 2003 оны 12 дугаар сарын 19-ний 36 дугаар хуралдааны тэмдэглэлд МУИС-ийн магистрант С.Мөнхнаранг

---

## Аудитын дүн

---

үнэ бүхий зүйлээр шагнахаар шийдвэрлэсний дагуу түүнд SONY ERICSSON маркийн гар утсийг 129,9 мянган төгрөгөөр худалдан авч өгчээ.

Усны хайгуул, судалгаа ашиглалтыг сайжруулахад зориулж төвлөрсөн арга хэмжээний зардлаас 40,0 сая төгрөг баталсан боловч уг мөнгөнөөс "Хог хаягдал ба экологи" баримтат кино бүтээхэд зориулж 24,0 сая, Байгаль орчны яамнаас олгодог хүндэт жуух, тэргүүний ажилтан цол тэмдгийн үнэмлэх хэвлүүлэх зардалд 1,2 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулжээ.

2003 оны 10 сард Байгаль орчны яамны ажлын албаны кассаас тус яамны Санхүү, төсвийн хэлтсийн дарга Т.Туулд томилолтын зөрүү нэрээр 600,0 мянган төгрөг бэлнээр гаргаад өнөөг хүртэл холбогдох тооцоог хийлгүй зардалд бичсэн байна.

**Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд төсвийн хөрөнгийг арвич хямгач, үр ашигтай зарцуулах талаар санаачлага муутай ажиллажээ.**

Байгаль орчны яам 2003-2004 оны шинэ жилийн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхдээ Байгаль хамгаалах сангаас 5,0 сая, Байгаль орчны яамны ажлын албаны төсвөөс 0,3 сая, Байгаль, ой, усны нөөцийн газраас 2,9 сая, Хүн Байгаль Орчин Консерциумаас 0,3 сая төгрөгийг бэлэн болон бэлэн бусаар төвлөрүүлж, нийт 8,5 сая төгрөг зарцуулжээ. Шинэ жилийн арга хэмжээний үеэр 14500 төгрөгийн үнэтэй 750 граммын виски 80 ширхэгийг 1160,0 мянга, нэг бүр нь 16000 төгрөгийн үнэтэй торт 90 ширхэгийг 1440,0 мянга, нэг бүр нь 4080 төгрөгийн үнэтэй вино 125 ширхэгийг 600,0 мянга, нэг бүр нь 5000 төгрөгийн үнэтэй MERCY шоколад 100 ширхэгийг 500,0 мянган төгрөгөөр худалдан авч уг арга хэмжээнд оролцогсдод гарын бэлэг болгон өгсний гадна оргилуун дарс, набор, шоколад, мэндчилгээ зэрэгт 2,3 сая төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 205 дугаар тогтоолоор "Цэвэр орчин" аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, түүнд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж байхаар заасны дагуу 2003 онд Байгаль орчны яамны төвлөрсөн арга хэмжээнээс уг аянд 30,0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 24,0 сая төгрөг зарцуулжээ. Энэ хөрөнгийн зарцуулалт үр дүнг холбогдох байгууллагуудад шалган үзэхэд:

- Байгаль орчны яамны Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газрын мэргэжилтэн С.Нарантуяа 2003 оны 12 дугаар сарын 23-нд "Цэвэр орчин" аяны хүрээнд үр бүтээлтэй ажилласан зарим аймгийн Засаг дарга нарыг урамшуулах зорилгоор 2,0 сая төгрөгийг кассаас бэлнээр аваад өнөөг хүртэл холбогдох эзэнд нь хүлээлгэж өгөөгүй нь баримтаар нотлогдож байгаа тул уг мөнгийг төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоов.
- Хог хаягдлын хууль эрх зүйн үндсийг боловсронгуй болгох,

хаягдлын менежментийг сайжруулах санал асуулга хийх ажлын хэсгийг орон нутагт ажиллуулахаар албан томилолтод олгосон 3,0 сая төгрөгөөс 1,045 сая төгрөгийг үндсэн баримтгүй олгосон тул холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

- “Байгаль орчны яамны тэргүүний ажилтан” тэмдэг хийлгэхээр 4,0 сая төгрөгийг зарцуулсан боловч уг тэмдгийг орлогод авалгүй шууд зардалд бичжээ.
- Дархан - Уул аймгийн Байгаль орчны албанд шилжүүлсэн 5,0 сая төгрөгийн сургалтын зардлын гүйцэтгэлийг шалгахад баримт бүрдүүлээгүй тул 5,0 сая төгрөгийг улсын төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх байдлаас харахад "Цэвэр орчин" аяны хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг нарийн тооцож хянахгүй байна. Уг аянд 2003 онд зарцуулсан нийт хөрөнгийн 33,7 хувь буюу 8,1 сая төгрөгийг зүй бусаар зарцуулсан байна.

**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д “Төсвийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн 13.2-т “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчиж төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.**

Байгаль орчны яам 2003 онд Монголын Сагсан бөмбөгийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын хүсэлтийн дагуу 300,0 мянган төгрөгийг хандив тусламж болгон өгчээ.

Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны Теле-студи байгуулж, түүнд шаардагдах техник хэрэгслийн үнэ 15,1 сая төгрөгийг 2001 оны 11 сард Валют арилжааны “Уянга-Эрдэнэ” ХХК-наар дамжуулан бэлнээр гаргаж аваад “Монголын шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэг” гэсэн төрийн бус байгууллагад өгчээ.

Байгаль орчны дэд сайд А.Болатын баталсан “Монголын шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэг”-ийн тэргүүн Д.Сумхүү, Байгаль орчны яамны Мэдээлэл, шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга Б.Баясгалан нарын хооронд байгуулсан “Байгаль орчны сурталчилгаанд ашиглах теле-студийг хамтарч байгуулах тухай” гэрээнд Байгаль орчны яамнаас тус студид авч өгсөн тоног төхөөрөмжийг 3 жилийн жилийн дараа “Монголын шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэг”-ийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэхээр заасан байна.

Энэ нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байгаа тул уг гэрээг холбогдох байгууллагаар шалгуулж, хөрөнгийг Байгаль орчны яамны нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд тусгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Байгаль орчны яам 2003 онд “Монголын шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэг”-т Монголын байлгаль орчин цуврал баримтат кино хийлгэх, телевизүүдэд захиалгат нэвтрүүлэг бэлтгэж, нийлүүлэх ажилд 69,9 сая төгрөгийн санхүүжилт өгчээ.

Энэ нь тендерийн холбогдолтой хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл юм.

**Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэнээр төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, төсвийн байгууллагуудыг мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтаас гадуур арилжааны банкинд харилцах данс нээхийг хуулиар хориглосон байхад Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд арилжааны банкуудад харилцах данс нээж гүйлгээ хийхээс гадна энэ ажил гүйлгээг тайлан, мэдээнд оруулалгүй, ямар нэг хяналтгүй зарцуулж байна.**

Байгаль, ой, усны нөөцийн газар “Ойн үндэсний хөтөлбөрийг дэмжих төсөл МОН/00/304”-ийн Голомт банкин дахь валютын 21620064, төгрөгийн 21450064 тоот дансуудад 2002 оны 7 дугаар сарын 17-ноос 2004 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүртлэх хугацаанд хушны самар түүсэн аж ахуйн нэгжүүдээс авсан байгалийн ургамал ашигласны төлбөрийн 33,1 сая, идлэг шонхор шувууны орлогоос өөрийн байгууллагын мэдэлд үлдээсэн 128,5 сая төгрөгийг тус тус оруулан, Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд 105,9 сая, РАJЕRО маркийн жип машин худалдан авахад 11,1 сая, УАЗ 396252 пургон автомашины 6,1 сая, компьютер техник хэрэгсэл авахад 6,2 сая, сэлбэг, материал, барилгын засвар зэрэгт 7,5 сая төгрөгийг тус тус зарцуулсны гадна Улсын мэргэжлийн хяналтын газраас хийсэн шалгалтаар байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байсан тул 13,1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолгож байжээ.

Байгалийн ургамал ашигласны дээрх төлбөрийн 2002 онд орсон орлогын үлдэгдэл 7,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Байгаль орчны сайдын 2003 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 143 дугаар тушаалаар Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааг Ой, усны хайгуул, судалгааны төвийн харъяанд байгуулжээ.

Дээрх тушаалд Монгол-Японы хамтарсан "Байгаль орчин" цэцэрлэгт хүрээлэн байгуулахад Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэх хөрөнгөөс урьдчилан зарцуулах хөрөнгийг тооцон Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Байгаль, ой, усны нөөцийн газраас 90,0 мянган ам.доллар буюу 103,8 сая, Байгаль, ой, усны нөөцийн газраас хашаа,

---

## Аудитын дүн

---

зам, талбайн ажилд 50,0 сая, Байгаль хамгаалах сангаас сургалтын зардал, тариалалтын бэлтгэл ажил 71,8 сая, төвлөрсөн арга хэмжээний зардлаас "Ховор ургамал, мод бутны тарьцны" үнэ 200,0 сая, бүгд 426,7 сая төгрөгийн санхүүжилт өгчээ.

Энэ хөрөнгийн зарцуулалтыг шалгахад хөрс шороо сайжруулах зардалд 29,3 сая, мод, суулгац тарих, худалдан авахад 206,1 сая, цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих зардалд 108,0 сая, бусад зардалд 56,6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа өнөөг хүртэл төрийн болон бусад хэлбэрээр улсын бүртгэлд бүртгэгдээгүйн гадна дээрх хөрөнгийг Голомт-6 банкинд байршуулан ажил гүйлгээг эрхлэн гүйцэтгэж байна.

Тус захиргаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан тэнцэл гаргаж тайлагнаагүйн гадна зарцуулсан нийт хөрөнгийн 93,2 хувь буюу 386,7 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулжээ.

Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа бэлэн мөнгөөр хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, худалдан авсан бараа, материалд хүн амын орлогын албан татвар тооцож аваагүйг нөхөн тооцож 3,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнд шаардагдах 200,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй модны тарьц суулгац худалдан авах, 108,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих ажил, 29,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрс сайжруулалтын ажил зэргийг тендерийн хууль, тогтоомжийн дагуу тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааг Ой, усны хайгуул судалгааны төвийн харъяанд байхаар сайдын тушаал гарсан ч санхүүжилт Байгаль орчны яам болон Байгаль, ой, усны нөөцийн газраас хийгдэж, Ой, усны хайгуул судалгааны төвөөс түүний гүйцэтгэлд хяналт тавих боломжгүй байдаг ажээ.

Байгаль орчны яам болон Байгаль, ой, усны нөөцийн газраас дээрх хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнд ямарч хяналт тавихгүй шууд зардалд оруулан тооцож байгаа нь их хэмжээний хөрөнгө төсвөөс гадуур зарцуулагдах гол шалтгаан болжээ.

Байгаль, ой, усны нөөцийн газар 2002 онд 303 ширхэг, 203 онд 392 ширхэг идлэг шонхор гадаадад гаргаж, улс, орон нутгийн төсөв, байгаль хамгаалах санд нийт 3307,9 сая төгрөг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 163 дугаар тогтоолоор 2002-2005 онд гадаадад гаргах идлэг шонхор шувууны тоог жил бүр 300 хүртэл толгой, түүний жишиг үнийг 4600 ам



---

## Аудитын дүн

---

доллар, төлбөрийг 3815 ам доллар, хураамжийг 365 ам доллар байхаар тогтоож өгсөн байна.

Идлэг шонхорыг гадаадад гаргаж байгаа гадаадын иргэд Ан агнуурын тухай хуулийн 5.1-д “Агнуурын амьтан агнах, барихад төлбөр, хураамж төлнө” гэсэн заалтыг үндэслэн ан агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамж төлөх ёстой.

Гэтэл Байгаль, ой, усны нөөцийн газар идлэг шонхорыг гадаадад гаргаж байгаа гадаадын иргэдээс нэг шонхор шувууны үнэнд дээр дурдсан жишиг үнээр тооцож төлбөр, хураамжийг авч зөрүү 420 ам долларыг өөрийн байгууллагын мэдэлд үлдээж зарцуулдаг байна.

Тус газар 2002 - 2004 онд 516,5 сая төгрөгийг өөрийн дансанд үлдээж, эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрээр Цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны санхүүжилт, сургалт, семинарын зардал, хөрөнгө худалдаж авах, гүний худгийн тооллого хийх, худаг гаргах, гадаадын зочид төлөөлөгчдийг дайлах, барилгын засварын ажил зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулжээ.

Энэ нь төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14.1.4-д “хуульд зааснаас бусад тохиолдолд төлбөр, хураамж авах, энэ хуульд заасныг зөрчиж нэмэлт бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг аливаа хэлбэрээр орлого олох”-ыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.

**Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 24, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн 3 дахь зүйлд заасны дагуу төсвийн байгууллага төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бүрдээ дээрх хууль, тогтоомжийг баримтлан тэдгээрийн гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж байх ёстой.**

Монголын байгаль орчин цуврал баримтат кино хийлгэх, телевизүүдэд захиалгат нэвтрүүлэг бэлтгэж, нийлүүлэх ажилд 69,9 сая, Байгаль орчны цэцэрлэгт хүрээлэнд модны тарьц суулгац худалдан авахад 227,0 сая, тус цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих ажилд 108,0 сая зэрэг ажил, үйлчилгээг худалдан авахдаа дээрх хуулийг баримталж ажиллаагүй байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34.2-т Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, экологийн боловсрол хүмүүжил олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор байгаль хамгаалах сан байгуулж ажиллуулах, энэ нь ямар эх үүсвэрээс бүрдэхийг тодорхой зааж өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам”-д

---

## Аудитын дүн

---

Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн эх үүсвэрийг дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн байгалийн баялаг ашигласан болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргасан тохиолдолд ногдуулсан нөхөн төлбөрийн 90 хувь
- Байгаль орчныг бохирдуулсны болон бусад хортой нөлөөлөл үзүүлсний төлбөрийн орлогын 50 хувь
- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны нэг удаагийн хураамжийн орлого
- Гадаадын иргэнд агнуулсан ан амьтны төлбөрийн орлогын 10 хувь
- Амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийн орлогын 10 хувь
- Хандив тусламж болон бусад эх үүсвэр

Дээрх журамд Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг байгаль хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дор дурдсан зориулалтаар зарцуулахаар заажээ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх
- Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сахиулах чиглэлээр хяналт шалгалтын ажил явуулах
- Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээнд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах
- Экологийн боловсрол, хүмүүжил олгох
- Байгаль орчныг хамгаалах талаар мэдээлэл сурталчилгаа явуулах
- Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон уулзалт, үндэсний болон олон улсын семинар, онол практикийн бага хурал, уулзалт, симпозиум зэрэг арга хэмжээг зохион байгуулах
- Байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сурталчлах, шинжлэн судлах үйл хэрэгт онцгой амжилт гаргасан өөрийн улсын болон гадаадын иргэдийг шагнах
- Байгалийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх

---

## Аудитын дүн

---

Санхүү, эдийн засгийн яам Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолын 4.11-ийг үндэслэн Байгаль хамгаалах сангийн 2003 оны орлогын төлөвлөгөөг 270.0 сая, зарлагын төлөвлөгөөг 300.3 сая төгрөгөөр хянаж, Байгаль орчны сайд энэ хэмжээгээр баталгаажуулсан байна.

Байгаль хамгаалах сангийн дансанд 2003 онд нийт 746.4 сая төгрөгийн орлого орж, 799.5 сая төгрөгийн зарлага гарсан байна.

Тус сангийн 2003 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт № 5-д үзүүлэв.

Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн байгалийн баялаг ашигласан болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргасан тохиолдолд ногдуулсан нөхөн төлбөрийн 90 хувь, байгаль орчныг бохирдуулсан болон бусад хортой нөлөөлөл үзүүлсний төлбөрийн орлогын 50 хувийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэх ёстой атал 2003 онд нэг ч төгрөг төвлөрүүлээгүй байна.

2003 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон дархан цаазат газрын харъяа Улсын байцаагчийн эрх авсан хүмүүс 39,5 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан байна.

Энэ байдлаас харахад Байгаль хамгаалах санд 35,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж байсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны нэг удаагийн хураамжийн орлогын төлөвлөгөө 34,4 сая төгрөгөөр давж биелэхэд хушны самрыг гадаадад гаргаж буй компани, хувь хүмүүсээс авсан байгалийн ургамал ашигласны төлбөр 21,75 сая төгрөгийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн нь голлон нөлөөлжээ.

Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулиар дээрх самрын төлбөрийг тухайн орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх ёстой.

Байгаль хамгаалах сангийн 2003 оны зарлагын гүйцэтгэлийг хавсралт № 6-д үзүүлэв.

2003 онд Байгаль хамгаалах сангаас зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн 92.4 хувийг хөрөнгө худалдан авах, хурал семинар зохион байгуулах, сурталчилгаа явуулах, Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээнд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах зэрэг арга хэмжээнд, 5,7 хувийг байгалийн баялгийг нөхөн сэргээх, байгаль орчныг

хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сахиулах чиглэлээр хяналт шалгалтын ажил явуулахад зарцуулахаар төлөвлөсний гадна хууль тогтоомжийн дагуу зарцуулах ёстой байгалийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сурталчлах, шинжлэн судлах үйл хэрэгт онцгой амжилт гаргасан өөрийн улсын болон гадаадын иргэдийг шагнаж урамшуулахад нэг ч төгрөг төлөвлөөгүй байна.

Байгаль хамгаалах сангийн 2003 оны батлагдсан төсвийг зардлын 4 төрөлд нийт 54.2 сая төгрөгөөр хэмнэж, 5 төрөлд 331,3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Батлагдсан төсвийг 331,3 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд гарах зардлыг 254,2 сая төгрөгөөр хэтрүүлсэн, 12 ширхэг суудлын автомашиныг 115,8 сая, Ус, цаг уур, орчны шинжилгээний газарт хэмжих багаж хэрэгсэл авахад 180,0 сая төгрөгөөр тус тус худалдан авсантай холбоотой байна.

**Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа эсэхийг аудитын шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан шалгалаа.**

**Байгаль хамгаалах сангийн ажлын алба сангийн хөрөнгийн зарим хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг хуурамчаар үйлдэж хууль тогтоомжийн дагуу бүрэн бүрдүүлээгүйн гадна батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.**

Сангийн 2003 оны нийт зарлагын 40,7 хувь болох 235,0 сая төгрөгийн ажил гүйлгээг тендер зарлаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг бүрэн бүрдүүлэлгүй зарцуулж зарлага болгосон байна. Дээрх зөрчлийг гүйлгээ тус бүрээр хавсралт № 7-д үзүүлэв.

Байгаль орчны сайдын 2002 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 236 дугаар тушаалаар гадаадын анчдад төлбөртэй ан агнуулах ажлыг шуурхай сайн зохион байгуулан хэрэгжүүлэхэд амжилт гаргасан “Жуулчин” ХК, “Адъяа энд Алтай” ХХК, “Монгол сафари” ХХК-ныг тус бүр 800.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулахаар шийдвэрлэж, 2002 оны 12 сарын 23-нд 2000.0 мянга, 2003 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 400.0 мянган төгрөгийг Байгаль хамгаалах сангаас тус тус бэлнээр гарган, шагнал нэрээр нягтлан бодох бүртгэлд тусгасан боловч дээрх компаниудад шагналын мөнгийг өгөлгүй 2002 оны шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Төрийн захиргаа удирдлага, хяналтын газрын дарга Г.Энхтүвшин 2002 онд 79062 төгрөгийг шатахуун авах нэрээр бэлнээр гаргуулж аваад өнөө хүртэл тооцоо хийгээгүйгээс Байгаль хамгаалах сангийн 2002 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд кассын үлдэгдлээр хий бичигдэж, 2003 оны тайлан тэнцэлд авлага байдлаар тусгагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэсэн байх”, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн 13.2-т “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу зориулалт бусаар, үр ашиггүй төсөл арга хэмжээнд зарцуулж, сангийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах талаар хангалтгүй ажилласан байна.**

Байгаль орчны сайдын 2003 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 231 дүгээр тушаалаар сангийн хөрөнгөөс 5,0 сая төгрөгийг зориулалт бусаар 2003 оны шинэ жилийн арга хэмжээнд зарцуулжээ.

“Байгаль орчин” цэцэрлэгт хүрээлэнгийн ажил эхлэхтэй холбогдуулан англи хэлтэй мэргэжилтэн шаардлагатай байгаа тул А.Цэцэгийг Англи улсад 1 жил 6 сарын хугацаагаар англи хэлний сургалтад хамруулах болж, Байгаль орчны сайдын 2004 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 05 дугаар тушаалын дагуу сургалтын төлбөр 8,9 сая төгрөгийг Цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны харилцах дансаар дамжуулан хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг “Энүүжин” ХХК-д шилжүүлсэн байна. Англи хэлтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг заавал их хэмжээний хөрөнгө зарцуулж, гадаад оронд бэлтгэхгүйгээр шийдвэрлэх бололцоотой юм.

Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журамд “Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээнд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтыг үндэслэн энэ арга хэмжээнд 2003 онд 104,7 сая төгрөг зарцуулсан байна.

Байгаль орчны сайдын 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 234 дүгээр тушаалыг үндэслэн “Дархан цаазат Богдхан уулын экосистемийн хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежмент, төлөв байдлын үнэлгээ” төслийг хэрэгжүүлэхээр Геологи, газар зүй судалгааны төвд 56,6 сая төгрөг олгожээ.

Дээрх хөрөнгийн гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнахдаа анхан шатны баримтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, мөнгөн урьдчилгааны тайланг гаргаагүй, судалгааны ажлын материалд тухайн онд хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг нарийвчлан тусгаагүй байлаа.

Байгаль орчны сайдын 2004 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 29 дүгээр тушаалыг үндэслэн Геологи газар зүй судалгааны төвд “Экологийн менежерийн сургалт” төслийг хэрэгжүүлэхээр 84,4 сая төгрөгийг олгожээ.

“Экологийн менежерийн сургалт”-ыг Улаанбаатар хотын бүх дүүргүүд,

---

## Аудитын дүн

---

Төв аймагт зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Монгол улсын их сургуулийн багш нарыг татан оролцуулсан байна.

Байгаль хамгаалах сангаас дээрх сургалтыг зохион явуулахад гүйцэтгэлээр 58,8 сая төгрөгийг зарцуулжээ. Уг хөрөнгийн гүйцэтгэлийг шалгахад баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй, цаг хугацааны хувьд зөрүүтэй байгаагийн гадна уг хөрөнгө бүрэн хэмжээгээр сургалтад зарцуулагдаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь хөрөнгө зарцуулах шийдвэрийн дагуу сангийн хөрөнгийг бэлэн болон бэлэн бусаар аваад тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүй, ирүүлсэн баримт материал, тайланг ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан шалгаж хүлээн аваагүй, ажил гүйлгээг данс бүртгэлд хуурамчаар хий бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14 дэх зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлэх, хандивлах, бэлэглэх, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргах зэрэг үйл ажиллагааг хориглосон байдаг.

Үндэсний аудитын газраас 2003 оны 9 дүгээр сард Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтыг хэсэгчлэн шалгаад тус сангийн ажлын алба 2002 онд 9 байгууллага, албан тушаалтанд 34.7 сая, 2003 оны эхний хагас жилд 3 байгууллагад 10.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх нөхцлөөр зээлдүүлснийг илрүүлж, төлөгдөөгүй үлдэгдэл 17.7 сая төгрөгийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэх акт тогтоосон билээ.

Байгаль хамгаалах сангийн төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс болон шагнал урамшууллын 4120.0 мянган төгрөгийн татвар ногдох орлогод хүн амын орлогын албан татвар ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн тул 412.0 мянган төгрөгийн хүн амын орлогын албан татвар, түүнд ногдуулсан хүү 206.0 мянган төгрөг, бүгд 618.0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх акт тогтоолоо.

Тус сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, тогтоомжийг баримтлаагүй зөрчил 2003 оны нийт зарлагын 38,5 хувийг эзэлж байна.

Тухайлбал 56.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Богдхаан уулын экосистемийн хамгаалал, нөхөн сэргээлтийн ажил, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн түвшинд судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажил, 24.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй захиалгат нэвтрүүлэг бэлтгэж телевизүүдэд нийлүүлэх ажил, 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Монгол орны байгаль орчин сэдэвт кино хийх ажлын гүйцэтгэгчийг тус тус шууд гэрээ байгуулах аргаар сонгосны гадна 2003 онд 115,8 сая төгрөгийн 12 ширхэг суудлын автомашиныг 10 байгууллагаас тендер зарлалгүй шууд

---

## Аудитын дүн

---

гэрээ байгуулан худалдаж авсан байна.

Байгаль орчны яамны Санхүү, төсвийн хэлтсийн санхүүгийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тус яамны харьяа зарим байгууллагуудад хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар холбогдох шийдвэрүүдийг удаа дараа гаргуулж байжээ. Үүнд:

Байгаль орчны сайдын “Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай” 2002 оны 137 дугаар тушаал, “Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах тухай” 2002 оны 216 дугаар тушаал, “Төсвийн санхүүжилт болон бүртгэл тооцооны талаар авах арга хэмжээний тухай” 2003 оны 186 дугаар тушаалыг тус тус гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад байгууллагынхаа санхүүгийн дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, гарсан зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгаж байжээ.

Гэвч дээрх шийдвэрийг аудитад хамрагдсан байгууллагын холбогдох албан тушаалтнууд хангалтгүй биелүүлсэн нь аудитын дүнгээс харагдаж байна.

Аудитаар нийт 33,5 сая төгрөгийн төлбөр, 520,1 сая төгрөгийн зөрчил илэрсний дотор нийт төлбөрийн 67,6 хувь нь Байгаль орчны яамтай, 23,2 хувь нь Байгаль, ой, усын нөөцийн газартай, 9,2 хувь нь Байгаль хамгаалах сантай холбоотой акт тус тус эзэлж байна.

Аудитаар төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулж ихээхэн хэмжээний төлбөр, зөрчил илэрсэн нь Байгаль орчны яамны Санхүү, төсвийн хэлтсийн удирдах албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй биелүүлсэнтэй холбоотой байна.

---

## Дүгнэлт

---

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, дүн шинжилгээнд тулгуурлан дараахь дүгнэлт хийж байна.

- Байгаль орчны яам 2003 онд дэвшүүлсэн зорилт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөг үндсэнд нь биелүүлсэн байна.
- Аудитад хамрагдсан байгууллагууд 2003 оны үйл ажиллагааны үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нэгтгэж тайлагнаагүйн гадна төсвийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаагүй, санхүүгийн тайлан мэдээг будлиантуулж, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг худал мэдээллээр хангаж байжээ.
- Аудитад хамрагдсан байгууллагууд батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн хөрөнгийг арвич хямгач, үр ашигтай зарцуулах талаар санаачлага муутай ажиллажээ.
- Мөнгөн хөрөнгийн нэгдсэн зохицуулалтаас гадуур мөнгө хөрөнгө зарцуулж, тухайн ажил гүйлгээг тайлан, мэдээнд оруулалгүй, хяналтгүй зарцуулж байна.
- Улсын төсвөөс ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд зориулж өгсөн хөрөнгийг холбогдох хууль эрхийн актын дагуу зарцуулж, энэ ажилд ахиц дэвшил гарсан байна.
- Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа хууль тогтоомжид заасан орлого, зардлын зүйл тус бүрээр бүрэн төлөвлөөгүйн гадна тухайн төсөл, арга хэмжээний ач холбогдлыг үнэлж, түүнтэй уялдуулан зардлын хуваарилалтыг оновчтой хийгээгүй байна.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материалыг бүрэн бүрдүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тус сангаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг хянаж холбогдох арга хэмжээ авах ажил шаардлагын хэмжээнд хийгдээгүй байна.